



**ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 дугаар сарын 31

Дугаар 02/20

Жаргалант сум

Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын “Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засаг дарга (Л.Учрал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш БИЛГҮҮНБААТАР

1024010081

**ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Удиртгал

Монгол Улсын “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн орон нутгийн хэмжээнд хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэх, бүрэн эрхийнхээ хугацаанд бүтээлчээр, хурдтай ажиллах зорилгоор 2024 оны ээлжит сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилтуудаа дэвшүүллээ.

Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжсэнээр сумын иргэн бүр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд, бүтээн байгуулалтын ажлын үр шимийг бодитой хүртдэг, оролцоо, дуу хоолой нь орон нутгийн хөгжил дэвшилд хувь нэмэр болдог, төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэйгээр авдаг болно.

Хүний хөгжлийг хангасан, амьдрах таатай орчин бүрдэж, төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдаж, төр иргэний хамтын ажиллагаа, ил тод, нээлттэй байдал дээшилнэ.

Энэхүү хугацаанд Орхон аймгийн Жаргалант сумын хэмжээнд хэрэгжүүлэхээр тусгайлан тусгасан дараах томоохон төсөл, үйл ажиллагааг төлөвлөж байна.

- “Эрүүл Жаргалантчууд”, “Жаргалантын ногоочид”, “Ногоон Жаргалант”, “Малжуулах”, “Боловсрол”, “Соёлыг дэмжих”, “Ахмадыг дэмжих” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- Жаргалант сумын 2032 он хүртэл хөгжүүлэх “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулж орон сууцны төсөл хэрэгжүүлнэ.
- Сумын инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан Жаргалант, Улаантолгой багуудын гэр хорооллыг инженерийн шугам, сүлжээнд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- Сумын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийг хийж, ашиглалтыг сайжруулна.
- Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд хоршоодыг дэмжин, малчдыг үйлдвэрлэгч өрх болгон хөгжүүлж, бүтээмжид суурилсан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байрыг шинээр бий болгож, ажилгүйдлийг бууруулж орлогыг нэмэгдүүлнэ.
- Эрүүл чийрэг хүүхэд бий болгох зорилгоор 330 сумаас анхдагч болж сумандаа хүүхдийн болон иргэдэд зориулсан усан бассейнтай болж, суралцагч нэг бүрийг амжилттай суралцахад чиглүүлнэ.

**Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2024-2028 оны үйл
ажиллагааны хөтөлбөрийн агуулга**

№	Бүлэг	Үйл ажиллагаа	Зорилтын тоо
---	-------	---------------	--------------

1.	ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	1. Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан	5
		2. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж	6
		3. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг	4
		4. Тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол	6
		5. Эрүүл Монгол хүн	4
2.	ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	1. Дэд бүтэц	7
		2. Хүнс, хөдөө аж ахуй үйлдвэрлэл	9
		3. Газрын харилцаа, барилга хот байгуулалт	5
		4. Соёлын бүтээлч үйлдвэрлэл	3
		5. Байгаль орчин, ногоон тогтвортой хөгжил	4
3.	НАЙДВАРТАЙ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	1. Төрийн үйлчилгээний ил тод байдал	7
		2. Амар тайван, аюулгүй сум	4
		3. Батлан хамгаалах, гамшгийн үеийн бэлэн байдал	2

НЭГ.ХҮНИЙ ХӨГЖИЛ

Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан

1.1. Гэр бүлийн гишүүд болон хүн амын бүлгүүдийн нийгмийн оролцоог хангана.
1.1.1. Гэр бүлийн гишүүдийн нийгмийн оролцоо, хандлагад эерэг өөрчлөлт гарч, болзошгүй эрсдэлээс хамгаалагдах нөхцөл бүрдсэн байна.

1.1.1.1. Гэр бүлд суурилсан хүний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.1.1.2. Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, салбар дундын болон хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулна.

1.1.1.3. Залуучуудын боловсролын болон мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог дэмжинэ

1.1.1.4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах, бэхжүүлэх, хамгаалах, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар бүх нийтийн жендерийн талаарх боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.2. Ахмад настны хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, асаргаа сувилгааны чанар, хүртээмж сайжирч, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжиж нийгмийн оролцоо нэмэгдэнэ.

1.1.2.1. Ахмад настанд зориулсан олон талт үйл ажиллагааг зохион байгуулан, хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж

1.2. Орон нутгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшинг бууруулна.

1.2.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийн чадавх дээшилж, тогтвортой, өрсөлдөх чадвартай ажлын байрны хүрээ өргөжсөн байна

1.2.1.1. Жижиг, дунд, хөнгөн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн чадавхыг сайжруулж, хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжин,

бүтээмжид суурилсан орон нутгийн онцлогт тохирсон 50-аас доошгүй ажлын байрыг шинээр бий болгож, ажлын байранд зуучлан ажилгүйдлийг бууруулна.

1.2.1.2.Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт тогтолцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.

1.2.1.3.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж, бүтээлч санаачилга, хандлага, ур чадварыг хөгжүүлнэ.

1.2.1.4.Өрхийн үйлдвэрлэлийг дэмжин, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг бий болгоно.

1.2.1.5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зорилтот бүлгийн иргэдийг байнгын болон түр ажлын байранд холбон зуучлах ажлыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар зохицуулна

1.2.1.6.Зорилтот бүлгийн иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээг хүн төвтэй, үр ашигтай, хүртээмжтэй хүргэнэ.

Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

1.3.Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгчдийг дэмжиж, хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлнэ.

1.3.1.Спортоор хичээллэгчдийг нэмэгдүүлнэ.

1.3.1.1.Нийтийн биеийн тамир, спортын орчныг сайжруулж, олон төрөлт тэмцээн уралдаан зохион байгуулан иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлан таниулна.

1.3.1.2.Спортын авьяасыг нээн илрүүлэх, мэргэжлийн болон үндэсний спортоор хичээллэгчдийн оролцоо, амжилтыг нэмэгдүүлж, тэдэнд дэмжлэг үзүүлэн, шинэ тутамд хөгжиж байгаа спортын төрлүүдийг хөгжүүлнэ.

1.3.1.3.Сумын хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлэхэд шаардлагатай материаллаг баазыг бэхжүүлж, дэмжлэг үзүүлэн, хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3.1.4.Эрүүл чийрэг хүүхэд бий болгох зорилгоор 330 сумаас анхдагч болж сумандаа хүүхдийн болон иргэдэд зориулсан усан бассейнтай болж, суралцагч нэг бүрийг амжилттай суралцахад чиглүүлнэ.

Тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол

1.4.Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.

1.4.1.Суралцах таатай орчин, бүрдэж, хүүхдийн хөгжил хангагдана.

1.4.1.1.Хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж боловсролын салбарын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, суралцагчдад ээлтэй сургалтын орчин бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.

1.4.1.2.Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, соёл, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.4.1.3.Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн онцлог хэлбэр, нөхцөл байдлаас үл шалтгаалан танхимын болон хувилбарт сургалтаар боловсролын үйлчилгээнд хамруулна.

1.4.1.4.Боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэйгээр зохион байгуулж, хүүхдийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах, боловсрол эзэмших сургалтын цахим систем нэвтрүүлж, бүх насны иргэдийг насан туршдаа суралцахуйн үйлчилгээнд хамруулах олон талт үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

1.4.1.5.Цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдэд шаардлагатай шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах олон талт арга хэмжээг асран хамгаалагчтай хамтран хэрэгжүүлнэ.

1.4.1.6.Боловсролын сургалтын байгууллагын багшлах боловсон хүчний мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих, ажлын үр дүнг бодитой үнэлэх, дүгнэх, урамшуулах, харилцан туршлага солилцох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Эрүүл Монгол хүн

1.5.Сумын хэмжээнд хүн амын дундах өвчлөл, нас баралт буурсан байна.

1.5.1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавх бэхжиж, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулсан байна.

1.5.1.1.Иргэний эрүүл мэндийн боловсрол, эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог төлөвшүүлж, иргэдийн дундаж наслалтыг өсгөх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.5.1.2."Эрүүл Жаргалантчууд" хөтөлбөрийг үргэлжлүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо эмчилгээний техник технологийн дэвшлийг нэвтрүүлж, орон нутагтаа оношлох, эмчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.5.1.3.Иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах боломжийг нэмэгдүүлж, алслагдсан багийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Явуулын тусламж үйлчилгээ"-г зохион байгуулах

1.5.1.4.Яаралтай тусламжийн болон хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний иж бүрдлийг шинэчлэн, үйлчилгээг сайжруулна.

ХОЁР.ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Дэд бүтэц

2.1.Дэд бүтцийн хүртээмж, найдвартай ажиллагаа нэмэгдэнэ.

2.1.1.Сумын хэмжээний эрчим хүч, инженерийн шугам сүлжээг үе шаттай шинэчилнэ.

2.1.1.1.Сумын инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан Жаргалант, Улаантолгой багуудын гэр хорооллыг инженерийн шугам, сүлжээнд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.1.1.2.Сумын хэмжээнд үерийн хамгаалалтын төлөвлөлт, ашиглалтыг сайжруулж, шинээр барих ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.

2.1.1.3.Сумын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийг хийж, ашиглалтыг сайжруулна.

2.1.1.4.Сумын цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэхэд шаардлагатай дэд станцыг барьж, шугам, сүлжээг өргөтгөн, ухаалаг удирдлагын систем нэвтрүүлж, шугамын алдагдлыг бууруулна.

2.1.1.5.Сумын төвийн барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулж, дулаан хангамжийн шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ус дулаан дамжуулах төвийг шинээр барьж иргэдийн амьдрах таатай орчныг бий болно.

2.1.1.6.Харилцаа холбооны шугам сүлжээг шинэчлэн өргөтгөнө.

2.1.1.7.Сумын авто замын, шинэчлэлт, өргөтгөл, их засварын ажлыг хийж, замын дагалдах дэд бүтцийг стандартын дагуу байгуулна.

Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

- 2.2. Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана.
- 2.2.1. Хүн амын хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулна.
- 2.2.1.1. "Хүнсний хангамж аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана.
- 2.2.2. Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ.
- 2.2.2.1. Усалгаатай газар тариаланг хөгжүүлж усалгааны системийг боловсронгуй болгож усалгааны нөхцөлийг сайжруулна.
- 2.2.2.2. Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд техник шинэчлэлийг үргэлжлүүлж, техникээр үйлчлэх дундын төв байгуулахад дэмжлэг үзүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.2.2.3. Хамгаалалттай хөрсний талбайг нэмэгдүүлж, өвлийн болон 3 улирлын хүлэмжийг хөгжүүлнэ.
- 2.2.3. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангана.
- 2.2.3.1. Бэлчээрийн менежментийг сайжруулж, худаг, усан хангамжийн хүрэлцээг тогтвортой байлгана.
- 2.2.3.2. Малын тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх, тэжээлийн ургамал тариалалтыг дэмжинэ.
- 2.2.3.3. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд хоршоодыг дэмжин, малчдыг үйлдвэрлэгч өрх болгон хөгжүүлж, орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.2.3.4. Малын үүлдэр угсааг сайжруулж, эрчимжсэн аж ахуйг дэмжиж мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.2.3.5. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалж, мал эмнэлгийн тоног төхөөрөмжийг сайжруулж, малын халдварт өвчингүй тайван байдлыг хадгална.

Газрын харилцаа, барилга хот байгуулалт

- 2.3. Иргэдэд амьдрах таатай орчныг бүрдүүлсэн төлөвлөлттэй хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бий болгоно.
- 2.3.1. Газрын харилцаа, хот төлөвлөлтийн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн хангах, хүртээмжийг дээшлүүлэх, цахим хэрэглээнд шилжүүлнэ.
- 2.3.1.1. Жаргалант сумын 2032 он хүртэл хөгжүүлэх "Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулж орон сууцны төсөл хэрэгжүүлнэ.
- 2.3.1.2. Сумын гудамж талбайн нэр, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах, тэмдэгжүүлэх хаягжилтыг сайжруулан хаягийн нэгдсэн системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлнэ.
- 2.3.1.3. Сумын нутаг дэвсгэрийн 2029 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- 2.3.1.4. Газар ашиглалт, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг сайжруулна.
- 2.3.1.5. Газар, үл хөдлөх, эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийн үйл ажиллагааг хангана.

Соёлын бүтээлч үйлдвэрлэл

- 2.4. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн орон нутгийн хөгжилд оруулах үр өгөөж нэмэгдэнэ.
- 2.4.1. Үндэсний өв соёл, ёс заншил, уламжлалаа хадгалан, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлж, иргэдэд үзүүлэх, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.

2.4.1.1.Соёлын биет болон биет бус өв, түүх соёлын үйл хөдлөх, дурсгалыг хадгалах, хамгаалах, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэн сурталчлах ажлыг олон нийтийн оролцоотой зохион байгуулна.

2.4.1.2.Соёл, урлагийн байгууллагад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёлыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.4.1.3.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож сумын наадмын талбайг стандартад нийцүүлэн барьж үндэсний өв, соёлын үйл ажиллагааг нь дэмжинэ.

Байгаль орчин, ногоон тогтвортой хөгжил

2.5.Хүрээлэн буй орчинд ээлтэй ногоон орчныг бий болгоно.

2.5.1.Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглуулж, нөхөн сэргээлтийг эрчимжүүлэн, хүрээлэн буй орчны бохирдол, доройтол буурна.

2.5.1.1.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Ногоон-Жаргалант хөтөлбөрийг эрчимжүүлж, эко системийн тэнцвэртэй байдлыг хадгалах санаачилгыг дэмжинэ.

2.5.1.2.Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.1.3.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах, байгальд ээлтэй хэмнэлттэй ногоон технологийг дэмжинэ.

2.5.1.4.Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментэд тойрог эдийн засгийн зарчмыг нэвтрүүлэх.

ГУРАВ.НАЙДВАРТАЙ ЗАСАГЛАЛ

Төрийн үйлчилгээний ил тод байдал

3.1.Төрийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.

3.1.1.Чадахуйн зарчимд суурилсан төрийн албыг бэхжүүлж, төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмж дээшилж, төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдана.

3.1.1.1.Төрийн байгууллагын цахим дэд бүтцийг хөгжүүлж, мэдээлэл харилцаа холбоо, шинэ технологийг нэвтрүүлэн шийдвэр гаргах үйл явцыг шуурхай, ил тод болгоно.

3.1.1.2.Төрийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор төрийн захиргааны төв байрыг барих ажлыг эхлүүлнэ.

3.1.1.3.Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулна.

3.1.1.4.Төрийн албан хаагчийн ёс зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулж, хариуцлагын тогтолцоог сайжруулна.

3.1.1.5.Олон улсын байгууллагууд болон харилцаа, хамтын ажиллагаат гадаад орнуудын муж, хотуудтай нийгэм, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3.1.1.6.Архивын сан хөмрөгт хадгалагдаж буй баримтын 50 хувийг цахимжуулж, баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.

3.1.1.7.Орон нутгийн хөгжлийн сан болон бусад тусгай сангуудын санхүүжилт, сонгон шалгаруулалтыг цахимжуулж, төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог сайжруулж, хуулиар хориглосноос бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.

Амар тайван, аюулгүй сум

- 3.2. Иргэдийн аюулгүй амар тайван амьдрах нөхцөл бүрдэнэ.
- 3.2.1. Сумын хэмжээнд гэмт хэрэг, зөрчил буурна.
- 3.2.1.1. Хууль тогтоомжийг сурталчлан бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.
- 3.2.1.2. Эрүүл, аюулгүй орчныг бий болгох зорилгоор дэвшилтэт технологи бүхий камерын хяналтын нэгдсэн системийг суурьшлын болон алслагдмал бүсийн 80 хувьд хүргэж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.2.1.3. Согтууруулах ундааны эргэлтэд тавих хяналтыг сайжруулж, архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.
- 3.2.1.4. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

Батлан хамгаалах, гамшгийн үеийн бэлэн байдал

- 3.3. Орон нутгийн хамгаалалт болон гамшгаас хамгаалах үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 3.3.1. Сумын батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах чадавх бэхжиж, гамшгийн бэлэн байдал хангагдана.
- 3.3.1.1. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг хангаж, батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулна.
- 3.3.1.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослыг зарлан мэдээлэх системийг өргөжүүлж, эрсдэлийн мэдээлэлд суурилсан гамшгаас хамгаалах удирдлага, үйл ажиллагааг хэрэгжүүлэн, гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог дэмжиж ажиллана.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны
12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдааны
0.9.10.1-д тогтоолын хоёрдугаар хавсралт

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үр дүн	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжээ	Суурь түвшин	Зорилготой түвшин				Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цагт хамтаг	Хариуцах байгууллага	
					2025	2026	2027	2028			Үндсэн	Хамтран
Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн												
1.	1.1. Гэр бүлийн гишүүд болон хүн амын бүлгүүдийн нийгмийн оролцоог хангана.	Гэр бүл, нийгэм рүү чиглэсэн олон талт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэд	Тоо	250	Жил бүр 10 хувиар нэмэгдүүлнэ /275/	Жил бүр 10 хувиар нэмэгдүүлнэ /325/	Жил бүр 10 хувиар нэмэгдүүлнэ /350/	Олон талт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо өссөн дүнгээр	Жилд 1 удаа	Нийгмийн ажилтан	Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг, Хамтарсан баг	
2.	1.2. Орон нутгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшинг бууруулна.	Ажилгүйдлийн түвшин	Хувь	16.9	16.4	15.9	15.4	14.9	Жилд 1 удаа	ЗДТГ	ХХҮГ-ын мэргэжилтэн, Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг, Статистикч	
3.	1.3. Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгчдийг дэмжиж, хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлнэ.	Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлсэн иргэд	Хувь	5.9	6.1	6.3	6.5	6.7	Жилд 1 удаа	БССАХМ	Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг, ЕБС	
4.	1.4. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.	СӨББ, ЕБС-ийн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	Хувь	ЕБС-72.8 СӨББ -87.2	ЕБС-76.0 СӨББ-87.4	ЕБС-78.2 СӨББ-87.6	ЕБС-79.4 СӨББ-87.8	ЕБС-80.0 СӨББ-88	Жилд 1 удаа	ЕБС, цэцэрлэг	БГ БССАХМ	
5.	1.5. Сумын хэмжээнд хүн амын дундах	Хүн амын дундаж наслалт	Жил	73.34	73.43	73.52	73.61	73.7	Жилд 1 удаа	ЗДТГ	ЭМТ, ЭМГ, Статистикийн хэлтэс	



өвчлөл, нас баралт буурсан байна.												насалтын хэмжээ, 2023 оны суурь түвшин						
6.	2.1.Дэд бүтцийн хүртээмж, найдвартай ажиллагаа нэмэгдэнэ.	Инженерийн дэд бүтцэд холбогдсон өрх	хувь	41.2 Орон сууцны 192 өрх	50.3 42 өрхөөр нэмэгдүүлж 234 өрх	50.3 234 өрх	50.3 234 өрх	50.3 234 өрх	71.8 100 өрхөөр нэмэгдүүлж 334 өрх			Инженерийн шугам сүлжээнд холбохоор төлөвлөсөн өрхийн тоог холбогдсон өрхийн тоотой харьцуулан өссөн дүнгээр тооцсон. (Гэр хорооллын Жаргалант баг 171 өрх, Улаантолгой баг 102 өрх)	Жилд 1 удаа	ЗДТ	ГХБХБГ, ЭУДТС ОНӨХК, ЭБЦТС ТӨХК, Жаргалант-Ус ДС ОНӨХК, Жаргалант, Улаантолгой баг			
7.	2.2.Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана.	Стандартын шаардлага хангасан орон нутгийн хүнсний үйлдвэрлэл эрхлэгч	Тоо	2	3	4	5	6				Өссөн дүнгээр тооцсон.	Жилд 1 удаа	ХААТ	ХХААГ, МЭГ, Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг, аж ахуй нэгж хувийн хэвшил			
8.	2.3.Иргэдэд амьдрах таатай орчныг бүрдүүлсэн төлөвлөлтэй сумыг бий болгоно.	Орон нутгийн мах, сүү, төмс хүнсний ногооны хэрэгцээгээ дотоодоос бүрэн хангах	Хувь	100	100	100	100	100				Статистик мэдээнд үндэслэн гаргана	Жилд 1 удаа	ХААТ	Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг, ГХБХБГ, Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг			
9.	2.4.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн орон	Төлөвлөгөөний биелэлт	Хувь	85.4	90	92	94					Тухай жилийн төлөвлөгөөний үнэлгээгээр тооцоолсон.	Жилд 1 удаа	Газрын даамал	БССАХМ, Жаргалант баг			


	нутгийн хөгжилд оруулах үр өгөөж нэмэгдэнэ.	эрхлэгчдийн тоо	Хувь	0	92.5	93	93.5	95	Үзэсгэлэн худалдаанд оролцогч соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн тоогоор тооцолсон.	Улаантолгой баг, Дулаан-Уул баг	
10.	2.5.Хүрээлэн буй орчинд ээлтэй ногоон орчныг бий болгоно.	Хөтөлбөрийн дундаж гүйцэтгэлийн үнэлгээ	Хувь	0	92.5	93	93.5	95	Тухай жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээгээр тооцсон.	Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг, Төрийн байгууллагуу ААН-үүд	
11.	3.1.Төрийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.	Төрийн үйлчилгээний талаарх судалгааны үр дүн	Хувь	-	-	Судалгааны дүн	-	2026 оны суурь судалгааны дүнг ахиулна.	Хөндлөнгийн судалгааны байгууллага р 2 жил тутам сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулна.	Судалгааны байгууллага	
12.	3.2.Иргэдийн аюулгүй амар тайван амьдрах нөхцөл бүрдэнэ.	Гэмт хэрэг зөрчлийн ирүүлэлтийн хувь	Хувь	95.2 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил 63, үүнээс илрүүлэлт 60.	100%	100%	100%	100%	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо, илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн тоотой харьцуулсан хувиар тооцолсон.	Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг, БОХ	
13.	3.3.Орон нутгийн хамгаалалт болон гамшгаас хамгаалах үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	Зохион байгуулсан арга хэмжээ тоо	Тоо	2	2	2	2	2	Тухай жилд зохион байгуулах арга хэмжээний тоогоор тооцолсон.	Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг	
Хөтөлбөрийн үр дүн											
14.	1.1.1.Гэр бүлийн гишүүдийн оролцоо, хандлагад	Гэр нийгэм чиглэсэн олон	хувь	250	Жил бүр 10 хувиар нэмэгдүүлнэ	Жил бүр 10 хувиар нэмэгдүүлнэ	Жил бүр 10 хувиар нэмэгдүүлнэ	Жил бүр 10 хувиар нэмэгдүүлнэ	Олон талт нөлөөллийн арга	Нийгмийн ажилтан	Хамтарсан баг

	зэрэг өөрчлөлт гарч, болзошгүй эрсдэлээс хамгаалагдах нөхцөл бүрдсэн байна.	талт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэд				/275/	/300/	/325/	/350/	хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо өссөн дүнгээр					
15.	1.1.2. Ахмад настны хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, асаргаа сувилгааны чанар, хүртээмж сайжирч, үргэлж хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжиж нийгмийн оролцоо нэмэгдэнэ. 1.2.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийн чадавх дээшилж, тогтвортой өрсөлдөх чадвартай ажлын байрны хүрээ өргөжсөн байна	Ахмад настанд үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан ахмад	Тоо	199	219	239	259	279	Жилд 1 удаа	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан ахмадын тоог өссөн дүнгээр тооцсон.	Ахмадын хороо	XXУГ-ын мэргэжилтэн, нийгмийн ажилтан, Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг			
16.		Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Хувь	61.5	61.7	61.9	62.1	62.3	Жилд 1 удаа	Хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувийг ажиллагчид эзэлж байгааг харуулна.	XXУГ-ын мэргэжил тэн	Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг, Аж ахуйн нэгж			
17.	1.3.1. Спортоор хичээллэгчдийг нэмэгдүүлнэ.	Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлсэн иргэд	Хувь	5.9	6.1	6.3	6.5	6.7	Жилд 1 удаа	Нийт иргэдээс идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэгч иргэдийн эзлэх хувь	БССАХМ	Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг, ЕБС			
18.	1.4.1. Суралцах таатай орчин, бүрдэж, хөгжил хангагдана.	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	Хувь	ЕБС-78.8 СӨББ-87.2	ЕБС-80.0 СӨББ-87.4	ЕБС-81.2 СӨББ-87.6	ЕБС-82.4 СӨББ-87.8	ЕБС-83.6 СӨББ-88	Хагас, бүтэн жилээр	Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулдаг багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дүнг өссөн дүнгээр тооцов	ЕБС, цэцэрлэг	БГ, БССАХМ			
19.	1.5.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавх бэхжиж, зонхилон тохиолдох халдварт	Халдварт өвчний тохиолдол	Продецим иль	18.2	17.5	17.0	16.5	16.0	Жилд 1 удаа	/10000 хүн амд ногдох/ 2023 оны суурь түвшин	ЭМТ	ЗДТГ, Жаргалант баг, Улаантолгой баг.			

	Болон халдварт бус өвчлөлийг бууруулсан байна.	Зурх судасны өвчин, хорт хавдар, амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин	Продецим иль	24.2	24.1	24.0	23.9	23.8	/10000 хүн амд ногдох/ 2023 оны суурь түвшин	Жилд 1 удаа	Дулаан-Уул баг.
20.	2.1.1.Сумын хэмжээний эрчим хүч, инженерийн шугам сулжээг үе шаттай шинэчилнэ.	Шинэчлэхээр төлөвлөсөн ИШСүлжээний ажлын гүйцэтгэл	Хувь	30	70	70	80	100	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг өссөн дүнгээр тооцолсон.	Хагас бүтэн жилээр	Жаргалант-Ус ДС ОНӨХК
21.	2.2.1.Хүн амын чанар, аюулгүй байдлыг хангуулна.	Хяналт хэрэгжүүлсэн объектын тоо	Тоо	14	15	16	17	18	Хяналт шалгалт хийх объектын тоог нэмэгдүүлж тооцсон.	Жилд 4 удаа	ХХААГ, МЭГ
22.	2.2.2.Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ	Тариалсан талбайн хэмжээ Хураасан ургацын хэмжээ	Га тн	Үр тариа 3841 га, тэжээлийн ургамал 269.7 га, төмс 111.3 га, хүнсний ногоо 390.5 га	Үр тариа 3800 га, тэжээлийн ургамал 270 га, төмс 115 га, хүнсний ногоо 391 га.	Үр тариа 3800 га, тэжээлийн ургамал 274га, төмс 120 га, хүнсний ногоо 391 га.	Үр тариа 3800 га, тэжээлийн ургамал 278 га, төмс 125 га, хүнсний ногоо 391 га.	Үр тариа 3800 га, тэжээлийн ургамал 280 га, төмс 130 га, хүнсний ногоо 391 га.	Статистик тоон мэдээг үндэслэн гаргана.	Жилд 1 удаа	Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг
23.	2.2.3.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангана.	Дархлаажуула лтад хамрагдсан малын тоо	Давхардсан тоо	273.1 тн	273.3 тн	273.5 тн	273.7 тн	273.9 тн	Тухайн жилд хамрагдах малын тоогоор тооцов.	Жилд 2 удаа	МЭГ, Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг
24.	2.3.1.Газрын харилцаа, төлөвлөлтийн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, хүртээмжийг	Төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	85.4	90	90	90	90	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр тооцолсон.	Жилд 1удаа	Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг

	Дээшлүүлэх, цахим хэрэглээнд шилжүүлэнэ.		Тоо	38124	39268	40445	41659	42909	Соёл урлагийн үйлчилгээ авсан иргэдийн тоог 3%-аар өссөн дүнгээр тооцоолсон.	Жилд 1 удаа	СМТ	БССАХМ
25.	2.4.1.Үндэсний өв соёл, ёс заншил, уламжлалаа хадгалан, бүх соёлын нийтийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд үзүүлэх, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.	Соёл мэдээллийн төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоо	Тоо	0	22.5	45.5	65.5	95.5	4 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх нийт ажлын жинд эзлэх хувиар өссөн дүнгээр тооцсон.	Жилд 1 удаа	БОХ	Байгаль орчны газар, Сумын Дундын ойн анги, Төрийн байгууллагуу А
26.	2.5.1.Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглуулж, нөхөн сэргээлтийг эрчимжүүлэн, хүрээлэн буй орчны бохирдол, доройтол буурна.	Төлөвлөсөн арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж	хувь									
27.	3.1.1.Чадахуйн зарчимд суурилсан төрийн албыг бэхжүүлж, төрийн үйл ажиллагааны хурд, талаар бүтээмж дээшилж, төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдана.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс гаргасан гомдол	Тоо	4	3	2	1	0	Иргэдээс гаргасан гомдлыг бууруулсан үзүүлэлтээр тооцоолсон.	Жилд 1 удаа	ЗДТГ	Төрийн байгууллагуу А
28.	3.2.1.Сумын хэмжээнд гэмт хэрэг, зөрчил буурна.	Гэмт хэрэг зөрчлийн тоо	Тоо	63	60	57	54	51	Бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулсан үзүүлэлтээр тооцоолсон.	Жилд 1 удаа	Цагдаагийн хэсэг	ГХУССЗ
29.	4.3.1.Сумын батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах чадавх бэхжиж, гамшгийн бэлэн байдал хангагдана.	Цэргийн шинэчилсэн бүргэл	Хувь	92.9	93	93.1	93.2	93.3	Тухай жилд бүртгэгдсэн иргэдийн хувиар өссөн дүнгээр тооцсон.	Жилд 1 удаа	ЗДТГ	Жаргалант баг, Улаантолгой баг, Дулаан-Уул баг
Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа												
